



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/27

Төмөрбулаг сум

Ой хээрийн түймрийн үед гарч ажиллах  
1,2-р ээлж болон хариуцах багаж болон  
бэлэн байдлыг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.13-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гал түймрийн аюултай үед ажиллах 1-р ээлжийг хавсралт 1-ээр, 2-р ээлжийг хавсралт-2-оор тус тус баталсугай.

2. Гал түймрээс урьдчилан сэргийлэх сурталчилгааг иргэн бүрт хүргэж урьдчилан сэргийлэх ажлыг сумын хэмжээнд зохион байгуулж ажиллахыг Байгаль орчны мэргэжилтэн, байгаль хамгаалагч /Д.Хишигсайхан, Ч.Амаржаргал/ нарт үүрэг болгосугай.

3. Айл өрх бүрт галын аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, гарын авлага тарааж, газар нутгийг иргэдэд хариуцуулан урьдчилан сэргийлэх ажлыг сайтар зохион байгуулж ажиллахыг багуудын засаг дарга нарт даалгасугай.

4. Ой хээр болон объектын гал түймэр гамшиг ослоос урьдчилан сэргийлэх түймэр гарч болзошгүй газруудад эргүүл шалгалтыг тогтмол хийж, хяналт тавьж ажиллахыг БО-ны мэргэжилтэн /Д.Хишигсайхан/-д даалгасугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/50 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

6. Захирамжийн хэрэгжилтийг хангуулан биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ЗДТГ-ын дарга /Г.Нямханд/-д үүрэг болгосугай.

ДАРГА

А.МӨНХ-ЭРДЭНЭ

